



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 4/90

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, аймгийн Онцгой комиссын 2024 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны А/649 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Цэцэрлэг, Цагаан-Уул сумдад зудын эрсдэлийн үнэлгээ хийх явцад байгууллагуудын машинд эвдрэл гэмтэл гарсан тул автомашины засварт зориулж зарцуулах хөрөнгийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Туулах чадвар сайтай автомашины бэлэн байдлыг хангах, Эрсдэлийн үнэлгээ хийх явцад гарсан тээврийн хэрэгслийн сэлбэг авах зардалд шаардагдах нийт 10,685,000 (Арван сая зургаан зуун наян таван мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 01-ны өдрийн 1 дугаар
захирамжийн хавсралт



НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Цагдаагын газар	Сэлбэг хэрэгсэл, засварын зардал	6,000,000
2	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сэлбэг хэрэгслийн үнэ	1,500,000
3	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	Сэлбэг хэрэгслийн үнэ	3,185,000
	Бүгд		10,685,000

-----oOo-----